

“МЖМС” ХХК
ЗАХИАЛАГЧ



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК
ГҮЙЦЭТГЭГЧ

2022

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



АРХАНГАЙ АЙМАГ, ТАРИАТ СУМ, СӨРТИЙН АМ

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК
Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөө
Газрын мэргэжлийн байгууллага

БАТЛАВ:

АРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.ЕШИЙ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“МЖМС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Д.МӨНХЖАРГАЛ

**АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМАНД БАЙРЛАХ “МЖМС” ХХК-ИЙН
“ДАЛАЙВАН ЦАГААН НУУР ЖУУЛЧНЫ БААЗ” ТӨСЛИЙН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5263808/

ХЯНАСАН:

АРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Г.БАТЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ДАВААСҮРЭН

Агуулга


Нэг. Төслийн товч танилцуулга	
1.1. Төслийн тодорхойлолт	1
1.2. Үсны хэрэглээ	4
1.3. Хог хаягдал	6
Хоёр. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	
2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	7
2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	8
Гурав. Тухайн жилийн (2022 он) байгаль орчны менежментийн төлөвлөгөө	
3.1. БОМТ-ний тухайн жилийн төлөвлөгөөний ажлууд	10
3.2. БОМТ-ний биелэлтийг дүгнэх аргачлал	14
3.3. БОМТ-ний биелэлт	16
3.3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
3.3.2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	19
3.3.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	20
3.3.4. БОМТ-г олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн биелэлт	20
3.3.5. Удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт	21
3.4. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	23
3.5. 2022 оны БОМТ-ний биелэлтийн дүгнэлт	26

Хавсралт

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт


Төслийн нэр:	"Далайван Цагаан нуур жуулчны бааз"
Төсөл хэрэгжүүлэгч:	"МЖМС" ХХК
Төслийн зорилго:	"Хорго-Тэрхийн Цагаан нуур"-ын байгалийн цогцолборт газарт аялагч, амрагчдын ая тухтай аялах, амрах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх
Улсын бүртгэл, Регистрийн дугаар:	0111208049 РД: 5263808
Утас:	99333883
Төслийн байршил:	Архангай аймаг, Тариат сум, Сөртийн ам-Хангай нурууны БЦГазарт, Өвгөн хадны зүүн хажууд, Тэрхийн цагаан нуурын зүүн хойно 174 м, Суман голоос 6.6 км, төв замаас 4.8 км, Улаанбаатар хотоос 520 км зайд байрладаг.
Талбайн хэмжээ:	2.0 га
Хүчин чадал:	Нэг удаад 100-150 амрагч, жуулчдыг хүлээн авна
Ажиллах хүч:	Захиргаа, маркетинг, санхүү, үйлчилгээ гэсэн хэсгүүдэд 10-15 хүн ажиллана
Ус хангамж:	Өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг
Цахилгаан хангамж:	Төвийн шугам сүлжээнд холбогдсон
Дулаан хангамж:	Цахилгаан халаалтаар шийдвэрлэдэг
Солбицол:	99° 48' 32.34" E 48° 8' 27.39" N 99° 48' 37.38" E 48° 8' 26.45" N 99° 48' 34.69" E 48° 8' 22.27" N 99° 48' 30.48" E 48° 8' 23.04" N



Зураг 1. Төслийн байршил

Төслийн хүчин чадал: Тус жуулчны бааз нь жилийн 4 улирлын турш ажиллах бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажиллахад нэг дор 100-150 хүн хүлээн авах хүчин чадалтай.

Жуулчны бааз нь гэр ресторан, 6 ортой Их таван ханатай гэр буудал - 16 ширхэг, 3 ортой урц - 6 ширхэг, халуун усны дүш, ариун цэврийн өрөө (боловсон) мөн, тоглоомын талбай, харуулын цамхагт байшин, авто зогсоол зэргээс бүрдэнэ.



Зураг 2. Жуулчны баазын ерөнхий төлөвлөгөө



Зураг 3. Рестораны гадна болон дотор орчин



Зураг 4. 6 ортой Их таван ханатай гэр



Зураг 5. 3 ортой үрц




Зураг 6. Харуулын байр



Зураг 7. Халуун усны дүш болон ариун цэврийн өрөө (боловсон)



Зураг 8. Бохирын цооног



Зураг 9. Ариун цэврийн өрөөний тохижилт

1.2. Усны хэрэглээ

Баазын усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Гүний худгийн цооногийг 2018 онд өрөмдөж гаргасан. Худаг нь 90 м гүн, усны тогтсон түвшин 30 м, ундарга 2.0 л/сек. QJX-1.1 маркийн хөдөлгүүртэй, QJX-1.1-120-5 маркийн ус өргөгч насосыг 67 м гүнд байрлуулсан. Одоогоор худгийг тоолууржуулаагүй.

Баазын усны хэрэглээг Архангай аймгийн БОАЖ-ын газрын 2021 оны 6 дугаар сарын 01 дугаартай "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг үндэслэн 5 жилээр дараах байдлаар тооцов

Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ: Жуулчны баазад 15 ажилтан ажиллах бөгөөд 1 ажилтанд шаардагдах усны хэмжээ 150 л/хоног.

Хүснэгт 1. Ажилчдын унд ахуйн усны хэрэгцээний тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л/хоног)	Ажиллах хүчин (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.л)
1	1 хоног	150	15	2.2
2	1 жил (160 хон)			202.5
3	5 жил			1012.5

Үйл ажиллагааны усны хэрэглээ: Жуулчны бааз нэг ээлжинд 100-150 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд зоогийн газарт өдөрт дунджаар 40 хүн 3 удаа хооллоно, хагас автомат ажиллагаатай угаалгын газарт өдөрт дунджаар 40 цагаан хэрэглэл угаахаар тус тус тооцоолов.

Хүснэгт 2. Зоогийн газрын усны хэрэгцээний тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л)	Хүчин чадал (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.л)
1	1 хоног	25	40*3 удаа	3.0
2	1 жил (90 хон)			270.0
3	5 жил			1350.0

Хүснэгт 3. Угаалга цэвэрлэгээний усны тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л)	Хүчин чадал (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.л)
1	1 хоног	85	40	3.4
2	1 жил (90 хон)			306.0
3	5 жил			1530.0

Жуулчдын усны хэрэглээ: Жуулчны бааз нэг ээлжинд 100-150 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд өдөрт дунджаар 40 хүн амрахаар тооцоолов. (Дундын ариун цэврийн өрөөтэй жуулчны баазын усны норм 180л/хоног)

Хүснэгт 4. Жуулчдын усны хэрэгцээний тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л/хоног)	Хүчин чадал (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.л)
1	1 хоног	180	40	7.2
2	1 жил (90 хон)			648.0
3	5 жил			3240.0

Мод усалгаа: 2021 оны 7 дугаар сард "Ногоо NGO" төслөөс 100 ширхэг хайлаас авч баазын хашаанд суулгасан. Усалгааг газрын гадаргын хэлбэржилтээс шалтгаалан жилд 8 удаа услахаар тооцоолов. (БОНХАЖСайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралт "Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм", 1 ширхэг суулгацын усалгааны норм 40л)

Хүснэгт 5. Мод усалгааны тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л)	Суулгац (ширхэг)	Шаардагдах усны хэмжээ (мян.л)
1	1 хоног	40	100	4.0
2	1 жил (8 удаа)			32.0
3	5 жил			160.0

Нийт ус хэрэглээ: Баазын үйл ажиллагаанд жилд 1.4 сая литр ус шаардагдах тооцоотой байна. Үүнд үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг дараах байдлаар тооцов. Үүнд:

$$1\text{м}^3 \text{ ус ашигласны төлбөр. } 1510 * 0.15 * 0.4 * 2 = 181.2 \text{ төг/м}^3$$

- Чулуут голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд экологи эдийн засгийн суурь үнэлгээ - 1510 төг

- Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ" 10. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэдэг ИААНБ-ын ашигласан усны шоо метр тутамд газрын доорх усны төлбөрийн хувь хэмжээ - 15%

- Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд газрын доорх ус ашиглалт тооцох итгэлцүүр - $0.4 * 2$ (Улсын тусгай хамгаалалттай газар нутагт ус ашигласан тохиолдолд экологийн итгэлцүүрийг 2 дахин нэмэгдүүлж тооцно)

Хүснэгт 6. Нийт ус хэрэглээ, усны нөөц ашигласны төлбөр

№	Үзүүлэлт	1 хоног	1 жил	5 жил	Усны төлбөр, төг/м ³	Усны нөөц ашигласны төлбөр, мян. төг/жил
1	Ажилчдын үнд ахуйн хэрэглээ, мян.л	2.2	202.5	1012.5	181.2	-
2	Амрагчдын ус хэрэглээ, мян.л	7.2	648.0	3240.0		117.4
3	Зоогийн газрын ус хэрэглээ, мян.л	3.0	270.0	1350.0		48.9
4	Угаалга цэвэрлэгээний ус хэрэглээ, мян.л	3.4	306.0	1530.0		55.4
5	Мод усалгаа, мян.л	4.0	32.0	160.0		5.8
	Нийт	19.8	1458.5	7292.5		227.5

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дүгээр заалтын дагуу хүн амын үнд ахуйн хэрэгцээнд ашиглах усыг төлбөрөөс чөлөөлнө.

1.3. Хог хаягдал


Жуулчны баазын оргил ачааллын үед хоногт 0.08-0.11тн хаягдал гарна гэж тооцвол жилд дунджаар 44 -63тн хатуу хог хаягдал үүсэхээр байна. Үүсч буй хог хаягдлын хэмжээг төрөл, бүтцээр нь дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. Жилд үүсэх хог хаягдлын хэмжээ

Эх үүсвэр		Ангилал	Үүсэх хэмжээ, м ³ /жил
Хатуу хог хаягдал, тн	Ажиллагсад	Дахивар	0.54-0.81
		Энгийн	1.26-1.89
	Жуулчид	Дахивар	35.07-54.11
		Энгийн	28.45-29.63
	Зоогийн газар	Дахивар	20.09-23.12
		Энгийн	19.71-26.28
Шингэн хаягдал, м ³	Унд ахуйн хэрэглээ	Дахин ашиглах боломжтой	3000-3170
	Үйлчилгээ		1344-1380
	Угаалга		1260-1300

Хүснэгт 8. Дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын төрөл		Хэмжээ, м ³	Дахин ашиглах арга хэмжээ
 Хатуу хаягдал, тн	Шил	11.1-15.7	Дахин боловсруулах боломжтой гялгар уут, хуванцар, шил лаазыг сумын төв дахь хоёрдогч түүхий эд боловсруулдаг хувь хүн, аж ахуйн нэгжид тушаах, бусад энгийн
	Лааз	4.91-6.93	
	Хуванцар	6.70-9.45	
	Гялгар уут	0.44-0.63	
	Шуудай	2.23-3.15	
	Цаас	1.34-1.89	
	Хоолны үлдэгдэл, ногооны хальс	17.8-25.2	Компост бордоо хийж ашиглах



Зураг 10. Нийт хог хаягдал болон дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хэмжээ, ангиллаар

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт сөргөөр нөлөөлөх үндсэн 2 нөлөөлөл байна. Үүнд:

- Тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисууд
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй, салхи шуурга ихтэй үед тоосжилт үүсэх

Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

Жуулчдын болон ажилчдын ахуйн хатуу хог хаягдал, бохир ус хөрсөн дээр ил задгай хаях асгах буюу хадгалвал хөрс бохирдуулах эх үүсвэр болно.

Зориулалтын зам талбайд тээврийн хэрэгсэл байрлуулаагүй, замбраагүй автомашины хөдөлгөөнөөс хөрс талхлагдах, хүнд металаар бохирдуулна.

Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны хүрээнд барилга байгууламж байгуулах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн улмаас үүссэн хөрсний эвдрэлийг дагаж ургамлан нөмрөгийн талхлагдал, доройтол үүснэ. Энэхүү эвдрэлээр ургамлан нөмрөг биет хэмжээгээр хохирч, ургамлан нөмрөг, байгалийн төрх өөрчлөгдөж хог ургамал бүхий бүлгэмдлээр солигдох, ургах орон зай нь багасахаас гадна ургамлын төрөл зүйл цөөрч бүрмөсөн устах магадлалтай.

Үйл ажиллагааны үед хатуу хог хаягдлыг хөрсөн дээр ил задгай хаях, эвдэрсэн газрыг сэргээн хөрсжүүлэх ажлыг орхигдуулах зэрэг үйл ажиллагаа нь хөрсийг бохирдуулж ургамлын бүтцийг өөрчлөн доройтуулах, улмаар ургац хомсдох нөхцөл болно.

Төслийн талбай нь суурьшлын бүс учир том хөхтөн амьтад болон зэрлэг ан амьтан байхгүй, харин жижиг мэрэгч амьтадтай. Тухайн орчны хөрс үйл ажиллагааны улмаас бохирдохын хирээр ургамлан нөмрөгт тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарах бөгөөд үүнтэй уялдан ургамал идэшт мэрэгч амьтдын амьдрах орчин доройтож, идэш тэжээлийн хомсдол үүсч болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл бага.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн талбайд явуулах аливаа үйл ажиллагаа ургамлын бүрхэвчийг доройтуулж, хөрсийг дагтаршуулах, элэгдүүлэх, эвдлэх зэргээс болж үерийн урсацын коэффициентийг ихэсгэнэ. Энэ нь үерийн урсацыг нэмэгдүүлэх эрсдэлтэй бөгөөд баазын талбай усанд автах, ус тогтох гэх мэт болзошгүй сөрөг нөлөөтэй.

Төслийн талбайд хамгийн ойр орших Тэрхийн Цагаан нуураас 174м зайтай тул гадаргын усанд шууд байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн газрын доорх усанд дараах сөрөг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Цэнгэг усны нөөцийг ашиглах
- Газрын доорх уст давхаргууд болон тухайн орчин дахь булгуудын гидравлик холбоо алдагдаж газрын доорх усны нөөцийн хомсдол үүсч болзошгүй
- Хог хаягдал, химийн бодис, шатах, тослох материал, бохир усны алдагдал, Суман голыг бохирдуулж болзошгүй.

2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ (Хүснэгт 9)

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ
Агаар	
Хог хаягдлыг ил задгай хаяж шатааснаар агаар орчин бохирдож болзошгүй	*Хог хаягдлыг сумын нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх, хориглосон, анхааруулсан самбар, хаяг хийж зохих газруудад байршуулах
Үйлчилгээний болон жуулчин тээврийн автомашины яндангаас болон ил гал түлж орчны агаарыг бохирдуулж болзошгүй	*Жуулчны баазын ойр орчимд шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх, ил гал түлэхгүй байх талаар мэдээллийн самбарт анхааруулга тавих
Хөрс	
Баазын засвар өргөтгөлийн ажлын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас хөрсөн бүрхэвч элэгдэх, барилга байгуулагдах талбайн хөрс эвдрэх	*Төслийн барилга байгууламж, зам талбайг тогтоосон зураг төслийн дагуу барьж байгуулах, тээврийн хэрэгслүүдийг тогтоосон замаар явуулах
Хаягдал бохир усыг хөрсөнд шууд шингээснээр хөрс бохирдож болзошгүй	*Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн бохир усыг бага оврын цэвэршүүлэх байгууламж ашиглан цэвэршүүлэн саарал усыг дахин ашиглах,
Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрсөнд нэвчиж бохирдол үүсэж болзошгүй	*Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн саванд хийж, түр хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт хүргэж байх, хогийн цэгийн халдваргүйжүүлэлтийг тухай бүрт нь хийх,
Тээврийн хэрэгслийн хэрэгсэл болон аялагчдын хэт их төвлөрөл, автозам зэргээс үүдэн хөрс эвдэрч элэгдэх, бохирдож болзошгүй	*Жуулчны баазын зам талбайг байгалийн материалаар засч тохижуулах, *Төв замаас бааз хүртэл нэг замтай байх ба "MNS 4597:2003, Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага" стандартын дагуу хаяг, замын тэмдэг байршуулах *Тээврийн хэрэгслийн зогсоол нь "MNS 5342:2007, Авто машины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага" стандартын дагуу авто зогсоолыг хийх
Ургамал	
Төсөл хэрэгжих талбай орчмын ургамлан бүрхэвч талхлагдах	*Төслийн барилга байгууламж, зам талбайг тогтоосон зураг төслийн дагуу төлөвлөх, төслийн талбайн сул зайг ургамалжуулах
Ус	
Баазын үйл ажиллагааны сөрөг нөлөө хатуу, шингэн хог хаягдал нь усны эх үүсвэрийг бохирдуулж болзошгүй	*Ундны усанд "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт" MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан эх үүсвэрийг ашиглах, *Унд ахуйн хэрэгцээнд ашиглах усыг нөөцөлж, хадгалахдаа хүнсний зориулалтын савыг ашиглах, *Ус хангамжийн эх үүсвэрт ариун цэвэр, хамгаалалтын бүс тогтоох
Амьтан	
Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, үргээх, нүүдэллэх боломжийг хязгаарлах, зөвшөөрөлгүй ан хийж болзошгүй	*Амьтдын амьдрах орчныг доройтуулахгүй, нүүдэллэх боломжийг хязгаарлахгүйн тулд баазын орчимд хаалт, хашилт хийхгүй байх, холбогдох хууль журмаар хязгаарласан, хориглосон зүйл заалтыг ажиллагсад болон аялагчдад сурталчилан таниулах, хяналт тавьж ажиллах

Ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдал	
Санамсар, болгоомжгүй байдлаас гал түймрийн аюул гарах, бэртэж гэмтэх	*Аялал жуулчлалын баазад "Галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага" MNS 4244:1994 стандартын дагуу хүний эрүүл мэнд, өмч хөрөнгийн хамгаалалтыг бүрэн хангасан байх шаардлагатай, *Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах
Төсөл хэрэгжих газар нутаг нь үерийн аюул, түймэрт өртөх, халдварт өвчин тархах зэрэг нөлөөлөлд өртөх	Үерийн уснаас хамгаалах даланг төслийн талбайн гадна талд хийх, түймэр, халдварт өвчний талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч харилцан уялдаа холбоотой ажиллах
Уламжлалт ариун цэврийн байгууламж ажилчид болон жуулчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	*Хог хаягдал түр хадгалах цэгийг гэр барилга байгууламжаас 50м-ээс дээш зайд байгуулах, тогтмол хугацаанд зайлуулах, Бохир усны савыг захын объектоос 20м, задгай усны эргээс 30м-с хол зайд байрлуулах, *Бохирын цооногт ариутгал, халдваргүйжүүлэлтийг ариутгалын бодис болон Биобэлдмэл ашиглан тогтмол эрүүл ахуйн норм, дүрмийн дагуу тогтмол хийх, *Эдэлбэр газрын талбай, гэр болон барилга байгууламжийн орчимд цэвэрлэгээг тогтмол хийх

ГУРАВ. 2022 ОНЫ БУЮУ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний ажлууд

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт эрхзүйн баримт бичиг
Ажилчдын аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр	Ажилтан бүрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт явуулах, мөрдөх	Баазын хүрээнд	220.0	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль
	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах		Үйл ажиллагааны зардлаар	
	Ажилчдыг жил бүр эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт оруулах		400.0	
	Эмийн сан, эмнэлгийн анхны тусламжийн хэсэгтэй байх		100.0	
Орчны аюулгүй байдлыг сайжруулах	Баазын ойролцоо байгаль орчныг хамгаалах, бохирдлын эсрэг мэдээлэл сурталчилгааны болон анхааруулах самбар байршуулах	Баазын хүрээнд	Үйл ажиллагааны зардлаар	-
	Тээврийн хэрэгсэл, явган хүний зам, зогсоолыг байгалийн аргаар засаж тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх			Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Усан орчинг сайжруулах чиглэлээр	Ус бохирдуулсны төлбөр төлөх		149.85	Усны тухай хууль, Ус бохирдуулсны тухай хууль
Бусад	Стандартын дагуу гал тогоо барих	Баазын хүрээнд	Дотоод зардлаар	-
	Тоглоомын талбай, сүүдрэвч барих			-
	Амрагчдын 2 ш торхон байшин барих			-
Нийт зардал			869.65	

Хүснэгт 11. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжих хугацаа, давтамж	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөрсөн бүрхэвчийг хамгаалах	Нийт эзэмшил талбайн 10-20%-иас доошгүй хэмжээний талбайд мод тарих	Баазын хүрээнд	Төсөл хэрэгжих нийт хугацаанд	Тайлбар: Хайлаас 5ш, Шар хуайс 5ш, Улиас 10ш, Чацаргана 10ш, Монос 5 бут гэж тооцов 300.0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4, Нийслэлийн Засаг Даргын 2013 оны А/623 дугаар захирамж
	Арчилгааны зардал			100.0	
Нийт зардал			-	400.0	

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Хаягдал усыг сар бүр соруулан зайлуулах Цаашид бохир ус цэвэрлэх байгууламж суурьлуулах (Зөгийн үүр технологи "Ховд тул" ХХК)	Аялал жуулчны баазын хүрээнд	Жилд ойролцоогоор 15 удаа зайлуулдаг 200.0төг*15	"Эрүүл ахуй" тухай хуулийн 3.1.1 зүйл
	Хог хаягдлыг ангилан ялгаж сумын нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх		8сар*24.0 192.0	"Хог хаягдлын тухай" хуулийн 10.2.3, 10.2.4-р зүйл
	Хог хаягдал төвлөрүүлэх цэгийг торлож, суурийг цементлэн тохижуулах		-	"Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх" тухай хууль
	Хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хүнсний хаягдлыг усгүйжүүлж органик компост бордоо болгон зүлэг, мод арчилгаанд ашиглах			"Хог хаягдлын тухай" хуулийн 10.2.8-р зүйл
Нийт зардал			3.192.0	

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал нь тухайн жилд жилийн үйл ажиллганы хүчин чадал, технологийн шинэчлэл, засвар үйлчилгээний зардлаас хамааран өөрчлөгдөнө.

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний ажил

Хяналт шинжилгээний хий үзүүлэлтүүд	Хяналтын байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах стандарт, арга аргачлал
Хөрс						
Хром, Cr	Хог хаягдлыг түр хадгалах цэг Авто зогсоол	-	Жилд 1 удаа	61.0	61.0	Баримтлах стандарт: "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850:2019
Хар тугалга, Pb						
Кадмий, Cd						
Никель, Ni						
Цайр, Zn						
Зэс, Cu						
Төмөр, Fe						
Ус						
pH	Унданд хэрэглэж буй ус	-	Жилд 1 удаа	46.0	46.0	Баримтлах стандарт: "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018
Ерөнхий хатуулаг						
Хлорид ион						
Сульфатын ион						
Кальцийн ион						
Магнийн ион						
Натри ион						
Хуурай үлдэгдэл						

Агаар						
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO	Баазын хашаанд, салхины доор 50м орчимд	-	Жилд 1 удаа	33.5	33.5	Баримтлах стандарт: "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016 Баримтлах стандарт: "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага" MNS 5002:2000
Хүхрийн давхар исэл, SO ₂						
Азотын ислүүд, NO _x						
Нийт тоос, TSP						
Нийт	140.5					

12

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан тооцоо	Хэрэгжих хуваарь Хугацаа: он, сар, өдөр	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажилтантай байх	Цалингийн зардлаар тооцно.	Төсөл хэрэгжих хугацаанд	Менежер	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн (14.1) хэрэгжилт хангагдана.
Байгаль орчны хуваарьт аудитыг 2 жил тутамд хийлгэх	Гэрээний үнийн дүнгээр тооцно.			Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн (10 ¹ зүйл)
Хог хаягдлыг ангилан ялгах дахин ашиглах талаар мэдээлэл хийх	Дотоод зардал			3 сард нэг удаа
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт явуулах.		14 хоногт 1 удаа	ХАБЭА-н ажилтан	Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлнэ.
Ажилчид болон жуулчдад байгаль орчныг хамгаалах талаар мэдээллийн чанартай самбар байршуулах	Гэрээний үнийн дүнгээр тооцно.	Төсөл хэрэгжих хугацаанд	Менежер	ТХГ нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих шаардлага MNS 6424:2013
Болзошгүй осол, аюулын үед орон нутгийн эмнэлэгийн болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулах				Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлнэ.
Нутгийн иргэдийн гар урлалын бүтээгдэхүүн болон бусад бараа бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын үйл ажиллагаандаа ашиглах, иргэдийг дэмжиж хамтран ажиллах	Гэрээний үнийн дүнгээр тооцно.	Төсөл хэрэгжих хугацаанд	Менежер	-
Нийт зардал	-			

Хүснэгт 15. БОМТ-г эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тоо	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах албан, тушаалтан/ажилтан	Зохион байгуулах хэлбэр
Аймаг, сумын иргэд	Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх, санал авах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 4, 10 саруудад	Дотоод зардлаар	Компанийн удирдлагууд	Аймаг, сумын иргэний танхимд
Шаардлагатай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны төрийн бус байгууллага		Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил				Компанийн төв байранд
Тусгай хамгаалалттай газрын захиргаанд		Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний чиглэлээр хийгдэж буй ажил				Хамгаалалтын захиргаанд
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах	Жил бүрийн 12-р сарын 31-ээс өмнө	Компанийн төв байранд			

3.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх аргачлал

БОМТ-нд тусгагдсан ажил тус бүрийн биелэлтийг үнэлэхдээ тухайн арга хэмжээ болон ажил, үйлчилгээний нарийн төвөгтэй байдал, гүйцэтгэлийн түвшин, цаг хугацаандаа гүйцэтгэсэн байдал зэргийг харгалзан дүгнэсэн болно.

3.2.1. Ажил, үйлчилгээний нарийн төвөгтэй байдлыг тодорхойлох

4	8	12	16	20
Маш төвөгтэй; ямар нэг ажил хийгдээгүй (суурь түвшин байхгүй)	Төвөгтэй; бэлтгэл болон боловсруулалтын ажил бага зэрэг хийгдсэн (суурь түвшин бага)	Бага зэрэг төвөгтэй; өмнө нь нэлээд ажил хийгдсэн (суурь түвшин талаас илүү)	Энгийн; нийт хийгдэх ажлын ихэнх хэсэг нь хийгдсэн (суурь түвшин өндөр)	Энгийн; тухайн ажлыг гүйцэтгэхэд шинээр хийгдэх ажил байхгүй

3.2.2. Гүйцэтгэлийн түвшинг тодорхойлох

10	20	30-40	50	60
Бэлтгэл болон боловсруулалтын эхний шатны ажил хийгдсэн	Нийт ажлын 40% хийгдсэн (ихэнх шалгуур үзүүлэлтийг хангаагүй)	Нийт ажлын 60% нь хийгдсэн (зарим шалгуур үзүүлэлтийг хангасан)	Нийт ажлын 80% нь хийгдсэн (ихэнх шалгуур үзүүлэлтийг хангасан)	Шалгуур үзүүлэлт бүрээр үр дүнд хүрсэн, хүрэх ёстой үр дүнг давуулан биелүүлсэн

3.2.3. Ажил үйлчилгээг цаг хугацаандаа гүйцэтгэсэн байдлыг тодорхойлох

4	8	12	16	20
Өөрөөс хамаарах шалтгаанаар хугацааг нэлээд хоцроосон	Өөрөөс хамаарах шалтгаанаар хугацааг бага зэрэг хоцроосон	Өөрөөс хамаарахгүй шалтгаанаар хугацааг нэлээд хоцроосон	Өөрөөс хамаарахгүй шалтгаанаар хугацааг бага зэрэг хоцроосон	Ажил, үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд нь буюу тухай бүр гүйцэтгэсэн

3.2.4. Үнэлгээний нийлбэр дүнгээр гэрээний биелэлтийг үнэлэх

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
90~100	80~90	70~80	60~70	0~60

Хүснэгт 16. Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх жишээ

№	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Үнэлгээ		
			1	2	3
1	Хөрс хамгаалах чиглэлээр	Олон салаа зам гаргахгүй байх	20/20	60/60	20/20
		Энэ ажлыг хэрэгжүүлэхэд төвөгтэй зүйл байхгүй тул 20 оноо, хүрэх ёстой үр дүнд хүрсэн тул 60, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн тул 20 оноо өгөв.	100/A		
2	Ажилчдын аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	20/20	60/50	20/10
		Хэрэгжүүлэхэд бага зэрэг төвөгтэй, нийт ажлын ихэнх хэсэг нь хийгдсэн/суурь түвшин өндөр тул 20, нийт ажлын 60% нь хийгдсэн, зарим шалгуур үзүүлэлтийг хангасан тул 50, өөрөөс хамаарах шалтгаанаар хугацаа хоцорсон тул 10 оноог өгсөн болно.	80/B		
3	Орчны аюулгүй байдлыг сайжруулах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байршуулах	20/8	60/40	20/10
		Энэ ажил хийгдээгүй болно.	58/F		

Дээрх аргачлалаар тухайн жилийн БОМТ-нд тусгагдсан ажил нэг бүрийг үнэлэх бөгөөд менежментийн төлөвлөгөө тус бүрийн эзлэх хувийг дараах хүснэгтийн дагуу тодорхойлно.

Хүснэгт 17. БОМТ-ний бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Эзлэх хувь, %	Үнэлгээ
1	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	35.0	Их
2	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25.0	
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	14.0	Дунд
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	12.0	
5	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	12.0	
6	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	3.0	Бага
Нийт		100.0	-

3.3. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

3.3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 18. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Үнэлгээ		
			1	2	3
Ажилчдын аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр	Ажилтан бүрт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт явуулах, мөрдөх	Сар бүр тогтмол сургалт зохион байгуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа бүхий самбар байршуулсан.	20/20	60/60	20/20
	Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Бүх ажиллагсдыг дүрэмт хувцсаар хангасан	20/20	60/60	20/20
	Ажилчдыг жил бүр эрүүл мэндийн нэгдсэн үзлэгт оруулах	Жил бүр ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг	20/20	60/60	20/20
	Эмийн сан, эмнэлгийн анхны тусламжийн хэсэгтэй байх	Ажилчдын амрах өрөөнд анхны тусламжийн хайрцаг, эмийн сан байрладаг	20/20	60/60	20/20
Орчны аюулгүй байдлыг сайжруулах	Баазын ойролцоо байгаль орчныг хамгаалах, бохирдлын эсрэг мэдээлэл сурталчилгааны болон анхааруулах самбар байршуулах	Нуурын эрэгт байгаль орчныг хамгаалах тухай сурталчилгаа бүхий самбар байршуулсан	20/20	60/50	20/20
	Тээврийн хэрэгсэл, явган хүний зам, зогсоолыг байгалийн аргаар засаж тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх	Автомашин зогсоолыг модон шонгуудаар тусгаарлаж олсоор холбосон	20/10	60/50	20/20
Усан орчинг сайжруулах чиглэлээр	Ус бохирдуулсны төлбөр төлөх	Ус ашиглах дүгнэлт гаргуулж Ус ашигласны төлбөр төлсөн	20/20	60/60	20/20
Нийт дүн			95.7/A		

3.3.2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын ангилал	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Үнэлгээ		
			1	2	3
Ахуйн	Хаягдал усыг сар бүр соруулан зайлуулах	Бохир ус соруулан зайлуулах хувь хүмүүстэй хамтран ажилладаг.	20/20	60/60	20/20
	Цаашид бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулах		100/A		
	Хог хаягдлыг ангилан ялгаж сумын нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх	Хог хаягдлыг ангилан ялгах хогийн савуудыг байршуулсан, Сумын ТҮК-тэй гэрээтэй	20/20	60/60	20/20
	Хог хаягдал төвлөрүүлэх цэгийг торлож, суурийг цементлэн тохижуулах	Хог хаягдал ангилан ялгах хогийн савуудыг шаардлагатай цэгүүдэд байршуулсан.	20/15	60/60	20/20
	Хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хүнсний хаягдлыг усгүйжүүлж органик компост бордоо болгон зүлэг, мод арчилгаанд ашиглах	Энэ ажлыг одоогоор хэлэлцэж байгаа	20/10	60/30	20/10
Нийт дүн			87.5/B		

Баазын хашаанд болон автозогсоолын талбайд хог хаягдал ангилан ялгах хогийн савуудыг сумын гагнуурчинаар хийлгүүлж байршуулан төвлөрсөн цэг болгосон ба зоогийн газар, гэр буудал зэрэг шаардлагатай хэсгүүдэд тус тус жижиг хогийн савуудтай.

3.3.3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 20. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Биелэлт	Үнэлгээ		
		1	2	3
Нийт эзэмшил талбайн 10-20%-иас доошгүй хэмжээний талбайд мод тарих	Баазын хашаан дотор мод тарьж хашаалсан.	20/20	60/60	20/20
Нийт дүн		100/A		

"Аброри" ХХК-аас тус бүр 1300 төгргийн үнэ бүхий 1500 ширхэг хайлаас худалдан авсан. Мөн "Хорго" ТББ-аас 2021 оны 7 дугаар сард Тариат суманд хэрэгжүүлсэн "Horgo NGO" төслөөс тараасан 100 ширхэг хайлаас модыг баазын хашаанд тарьж хашаалсан, ургалт хэвийн явагдаж байна.

2022 онд Шар хуайс 5ш, Улиас 10ш, Чацаргана 10ш, Монос 5 бут тарьсан.

3.3.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн биелэлт

Хүснэгт 21. БОМТ-г эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийн биелэлт

№	Төлөвлөсөн ажил	Биелэлт	Үнэлгээ		
			1	2	3
1	Хэрэглэгчийн холбогдох албан тушаалтан, сум болон багийн иргэд, ИНХ, шаардлагатай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны төрийн бус байгууллагад мэдээлэл өгөх, танилцуулах	БОМТ-ний хэрэгжилт, үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажлын талаар сумын иргэд, орон нутгийн байгууллагад танилцуулж санал авдаг. Иргэд болон үйлчлүүлэгчдээс санал, гомдол хүлээн авч тухай бүрт нь холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.	20/20	60/60	20/15
			95/A		
2	Тусгай хамгаалалттай газрын захиргаанд				
3	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний чиглэлээр хийгдэж буй ажлаа тайлагнаж цаашид хэрэгжүүлэх болон хийгдэж буй ажилд зөвлөгөө, үнэлгээ авдаг.	20/20	60/60	20/20
			100/A		
Нийт дүн			97/A		

3.3.5. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 22. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	Үнэлгээ		
		1	2	3
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажилтантай байх	Ерөнхий менежер нь байгаль орчны менежерийн албан үүргийг хавсран гүйцэтгэдэг	20/20	60/60	20/20
		100/A		
Байгаль орчны хуваарьт аудитыг 2 жил тутамд хийлгэх	Төлөвлөгөөт аудитын ажил хийгдээгүй.	20/8	60/30	20/12
		50/F		
Хог хаягдлыг ангилан ялгах дахин ашиглах талаар мэдээлэл хийх	Мэдээлэл хийхээс гадна ангилан ялгах сав байршуулсан	20/20	60/60	20/20
		100/A		
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт явуулах.	Сар бүр сургалт зохион байгуулдаг	20/20	60/60	20/20
		100/A		
Ажилчид болон жуулчдад байгаль орчныг хамгаалах талаар мэдээллийн чанартай самбар байршуулах	Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч мэдээллийн самбар байршуулсан	20/20	60/50	20/20
		90/A		
Болзошгүй осол, аюулын үед орон нутгийн эмнэлэгийн болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулах	Баазад эрүүл мэндийн ажилтантай ба шаардлагатай тохиолдолд сумын эмнэлэгтэй хамтран ажилладаг	20/20	60/60	20/20
		100/A		

Нутгийн иргэдийн гар урлалын бүтээгдэхүүн болон бусад бараа бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын үйл ажиллагаандаа ашиглах, иргэдийг дэмжиж хамтран ажиллах	Нутгийн гар урчуудын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг	20/20	60/60	20/20
		100/A		
Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн хариуцлагаа биелүүлэх	Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг	20/20	60/60	20/20
		100/A		
Ус ашиглах гэрээ, хог хаягдлын гэрээг жил бүр сунгаж ажиллах	Тухай бүрт гэрээг сунгаж, татвар төлбөрүүдийг төлдөг. (төлбөрийн баримтуудыг хавсаргав)	20/20	60/60	20/20
		100/A		
Байгаль хамгаалах талаар хийгдсэн ажлын тайланг жил бүр аймгийн БОГ-т хүргүүлж байх.	Жил бүр тайлангаа хүргүүлдэг	20/20	60/60	20/20
		100/A		
Нийт дүн		94/A		

3.4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт 23. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Төлөвлөсөн ажил	Биелэлт	Үнэлгээ		
		1	2	3
		20/20	60/60	20/20
Агаарын чанар	2022 оны 10-р сарын 20-ны өдрийн баазын гадна орчны агаарыг Архангай аймгийн УЦҮОШТ Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.	100/A		
Хөрсний бохирдол (хог хаягдлын цэг болон авто зогсоол)	2022 оны 06-р сарын 20-ны өдрийн хөрсийг Архангай аймгийн УЦҮОШТ Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн.	20/20	60/60	20/20
		100/A		
Хэрэглээний ус	2022 оны 06-р сарын 12-ны өдрийн баазын хэрэглээний усыг Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн.	20/20	60/60	20/20
		100/A		
Нийт дүн		100/A		

3.5. Тухайн жилийн (2022 он) БОМТ-ний биелэлтийн дүгнэлт

БОМТ-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу "Цагаан уулын оргил" ХХК боловсруулав.

Архангай аймгийн Тариат сум, Сөртийн ам-Хангайн нурууны БЦГ-т хэрэгжиж буй "МЖМС" ХХК-ийн "Далайван Цагаан нуур жуулчны бааз" төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-нд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөө, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарьт төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт 28 арга хэмжээг төлөвлөснөөс төлөвлөгөөт хувиарын дагуу ажлын биелэлт нь 95.7/А буюу маш сайн үнэлгээтэй хэрэгжсэн байна. Тухайлбал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт, мэдээлэл зохион байгуулж ажилчдын аюулгүй ажиллагааг тогтмол хянан ажиллах, хог хаягдлыг ангилан ялгах сав байршуулах, орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн хүрээнд мод тарих, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд баазын хэрэглээний ус, орчны хөрс, агаарын шинжилгээ хийлгэсэн.

"Үндны усны стандарт. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандартуудтай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй хэвийн байлаа.

Баазын гадна агаарын шинжилгээний дүнгээр орчны агаар дахь SO_2 , NO_2 , нийт тоосны агууламж MNS 4585:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнгээр "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS5850:2019 стандарт хэмжээнээс хэтрээгүй байна.


Хүснэгт 24. БОМТ-ний биелэлт

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ, %	Биелэлтийн үнэлгээ, %
1	Сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	25.0	95.7
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	14.0	87.5
3	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	3.0	100.0
4	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	12.0	97.0
5	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	35.0	94.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	12.0	100.0
Нийт дүн		100.0	95.7

2022 онд төсөл хэрэгжүүлэгч тал Байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн нь харагдаж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

Менежментийн төлөвлөгөөний дагуу 2022 онд хийгдсэн ажлуудаас



Төвлөрсөн цэгүүд дэх хогийн савууд

Бохир ус соруулах үе



Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт



Ажилчдын хувцас



Агаарын чанарын сорьц авч буй байдал



Шинээр барьсан торхон байшин

22

“Далайван Цагаан нуур жуулчны бааз” төсөл

ХААН БАНК МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ/ TRANSFER SLIP

ОНУУУ САРИМ ӨӨРӨ/DO 2022 11 04

Тухайн үйлчилгээний мэдээлэл / Recipient's information

Мөнгөний байр / Банк чөлөөт хаяг / Location	Дүнхний №/ Account №	Нэр / Байгууллага нэр / Company Name / Organization or individual
Уулзвар / Branch	3171122115	МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА
Дүнхний дүн / Amount	Дүнхний дүн / Amount in words	Төлбөрийн төрөл / Payment type
1,200,000.00	МНД зууны нэгдэн таван зуун тусгай	Төлбөрийн төрөл / Payment type
Бэлтгэсэн өдөр / Date	Төлбөрийн үйлдлийн төлбөр / Transaction description & other notes	Төлбөрийн төрөл / Payment type
2022.11.04		

ХАРИУЛГАГЧИЙН БАЙРНАС ХЭСЭГ / For Customer use only:

ХААН БАНК-ЫН ХАНАГЧИЙН БАЙРНАС / For Bank use only:

Бэлтгэсэн өдөр / Date	Мөнгөний байр / Банк чөлөөт хаяг / Location	Дүнхний №/ Account №	Бэлтгэсэн өдөр / Date
2022.11.04	Уулзвар / Branch	3171122115	2022.11.04

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

НЭХЭМЖЛЭХ № 322050062856

ТАТВАРЫН АЛБА:
Татварын алба: Архангай
Татварын дэд алба: Тариат
Татварын гэрэл: 01010115-Малын тоо тоологын албан татвар
Тайланг хугацаа: 2022-11
Төлөх дүн: 268.500

ТАТВАР ТӨЛБӨГЧ:
Регистр / ТТД: А389050311
Татвар төлөгчийн нэр: ДАМБИЯН-НЯМ МЭНХСАРГАЛ
Нэхэмжлэх үүсгэсэн огноо: 2022-06-02
Төлөх огноо: 2022-06-02

QR code and barcode (322660062856)

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

НЭХЭМЖЛЭХ № 3221100718351

ТАТВАРЫН АЛБА:
Татварын алба: Архангай
Татварын дэд алба: Авлигын төвлөрсөн
Татварын гэрэл: 01030724-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан
Усны төлбөр
Тайланг хугацаа: 2022-11
Төлөх дүн: 58.5150-М

ТАТВАР ТӨЛБӨГЧ:
Регистр / ТТД: 5263808
Татвар төлөгчийн нэр: МЖМС
Нэхэмжлэх үүсгэсэн огноо: 2022-11-04
Төлөх огноо: 2022-11-04

QR code and barcode (3221100718351)

Ус ашигласны төлбөрийн баримт

НХМЗалт БМ-3

Сонгийн сабдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хэсэгт

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Регистрийн №: 2022.11.04

№	Материалын үнэт зүйлсийн нэр, хэмжээ, дугаар	Мөнгөний үнэ	Төгс	Хувиартай үнэ	Нийт үнэ
1	Хөдөлгөөн / 90	90	90	1000	90000
2	Хөдөлгөөн / 30	30	30	1500	45000
3	Хөдөлгөөн / 80	80	80	1000	80000
4	Хөдөлгөөн / 80	80	80	1000	80000

Нийт дүн: 268.500

ХААН БАНК-ЫН ХАНАГЧИЙН БАЙРНАС / For Bank use only:

ХААН БАНК МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ/ TRANSFER SLIP

ОНУУУ САРИМ ӨӨРӨ/DO 2022 11 04

Тухайн үйлчилгээний мэдээлэл / Recipient's information

Мөнгөний байр / Банк чөлөөт хаяг / Location	Дүнхний №/ Account №	Нэр / Байгууллага нэр / Company Name / Organization or individual
Уулзвар / Branch	3171122115	МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА
Дүнхний дүн / Amount	Дүнхний дүн / Amount in words	Төлбөрийн төрөл / Payment type
1,200,000.00	МНД зууны нэгдэн таван зуун тусгай	Төлбөрийн төрөл / Payment type
Бэлтгэсэн өдөр / Date	Төлбөрийн үйлдлийн төлбөр / Transaction description & other notes	Төлбөрийн төрөл / Payment type
2022.11.04		

ХАРИУЛГАГЧИЙН БАЙРНАС ХЭСЭГ / For Customer use only:

ХААН БАНК-ЫН ХАНАГЧИЙН БАЙРНАС / For Bank use only:

Бэлтгэсэн өдөр / Date	Мөнгөний байр / Банк чөлөөт хаяг / Location	Дүнхний №/ Account №	Бэлтгэсэн өдөр / Date
2022.11.04	Уулзвар / Branch	3171122115	2022.11.04

ХАВСРАЛТ

1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2. Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээний хуулбар
3. Ус ашиглах гэрээний хуулбар
4. Худгийн паспортын хуулбар
5. Хог хаягдлын гэрээний хуулбар
6. Төлбөр төлсөн баримтуудын хуулбар
7. Архангай аймгийн МХГ-ын нэгдсэн лабораторийн усны шинжилгээний дүнгийн хуулбар
8. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаал, "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.12.12-ны өдрийн А/349-р тушаал "Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл"
- "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж", 2019 он
- Байгаль орчны хуулийн эмхэтгэл, УБ хот, 2012 он
- БОНХАЖСайдын 2015 оны А-138 тоот тушаал, "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"
- Архангай аймгийн БОАЖ-ын газар, "Ус ашиглуулах дүгнэлт", 2021 он
- БОАЖЯ, "Усны холбогдолтой батлагдсан хууль, тогтоол, тушаал, дүрэм, журам, нормын эмхэтгэл", 2016 он
- "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 4585:2016 стандарт
- "Ундны усны стандарт. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандарт
- "Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 5850:2019 стандарт
- Бусад холбогдолтой мэдээ материал

ЦАХИМ ХУУДАС

www.mne.mn

www.estandart.mn

www.ub.gov.mn

www.ser.nl

www.legalinfo.mn

nema.gov.mn

www.eic.mn

limitvalue.ifa.dguv.de



Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан уулын оргил” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн Чөлөө
“Бизнес плаза” 501 тоот
Утас: 7013 1114, 9918 4930
И-мэйл: tsagaanuuuliinorgil@gmail.com